# ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | | | | |
| 1.1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх. | Түгээсэн мэдээлэл, иргэдийн хандалтын тоо, Харьяа газар нэгжийг хамруулсан тоо | Хандалтын тоо 60.000 иргэн<br><br>“АЭҮА-ны тайлан-2022” | 65.000 иргэнээс доошгүй | Авилгатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, нийтлэл, зурагт хуудаснуудыг сумын ӨВА Тараг сум грүпп, Тарагт сум Засаг даргын Тамгын газар, Тарагт сумын зарын грүпп, Тарагт сумын малчдын грүпп, Тарагт Эрүүл Мэндийн Төвийн грүпп-д мэдээллийг шэйрлэж ажилласан. Хандалтын тоо нийтдээ 231 байна. |
| 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах. | Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо | 3 ажил, арга хэмжээ зохион байгуулсан<br><br>“АЭҮА-ны тайлан- 2022 | Нөлөөллийн 4 ажил арга хэмжээ зохион байгуулах | 2024 оны 4-р сард Төрийн байгууллагын дарга эрхлэгч нар болон байгууллагын нягтлангуудад “Авлига, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх” тухай сургалт зохион байгуулж зөвлөгөө өгсөн. Нийт төрийн байгууллагын грүпп болон сумын грүпп дээр 110 утасны талаарх мэдээллийг тавьж иргэдэд сурталчилсан. Хандалт 120. ЗДТГ-ын 27 албан хаагчид авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл зөвлөгөөг өгсөн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах. | Шинэчилсэн мэдээллийн тоогоор | - | Сар бүр шинэчлэх | Авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллийн самбарыг шинэ байранд орохдоо хийхээр төлөвлөсөн. |
| 1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх. | Боловсруулсан матеариал, бэлтгэсэн нийтлэл нэвтрүүлгийн тоо | 1000 ш тараах материал | 2 доошгүй сурталчилгааны материал боловсруулах 2 доошгүй нэвтрүүлэг, контент бэлтгэн цацах | 2024 оны 06-р сард болсон Туяа, Арвайнтал, Хүрэмт, Урт, Ихбулаг, Алтантал багуудын хурал дээр сумын албан тушаалтнуудын мэдээллийг танилцуулж, утасны дугааруудыг гарын авлага хэлбэрээр малчдад тараасан. Үүн дээр 110 утасны талаар мэдээллиг давхар оруулж өгсөн. |
| Зорилт 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | | | | |
| 2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | 90 | Шинэ томилогдсон албан хаагчдыг | Засаг даргын Тамгын газарт шинээр томилогдсон албан хаагчдад танилцуулах мэдээллийн хавтас байдаг. Үүн дотор байгууллагын мэдээллээс гадна авлига, ашиг сонирхлоос ангид байх ёстойг анхааруулсан зөвлөмж байдаг.<br><br>Төсөвт албан байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон 1, 2-р гарын үсэг зурдаг албан хаагч нийт 13 хүний хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд авч тайлагнасан. Удирдах албан тушаалтнуудад албан хаагч томилох, чөлөөлөхтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгч ажилласан<br><br>Сумын цахим хуудсуудаар Авлигатай тэмцэх газраас явуулж буй контентуудыг тавьж сурталчилсан. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл, ХЭДСангийн ажлын хэсгийн гишүүдээр мэдэгдэлийг тогтмол бөглүүлж цахим |
| 2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Хамтран ажилласан байгууллага, арга хэмжээний тоо | - | 2 доошгүй арга хэмжээ зохион байгуулах | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | системд бүртгэж байна. Мөн төрийн байгууллагууд хамтран ажилладаг байгууллага АН-үүдтэй гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй эсэн мэдэгдэх хуусыг тогтмол бөглөж хэвшихийг байгууллагын дарга, эрхлэгч нарт зөвлөн ажиллаа. |
| Зорилт 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | |
| 3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх. | Авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгасан гэрээний тоо | 4 төрлийн гэрээнд | 20 доошгүй гэрээнд тусгасан байна | ОНХСангийн хөрөнгөөр шууд гэрээг 5 байгууллага, хувь хүнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Уг гэрээнд ашиг сонирхлоос ангид байх, ямар нэг байдлаар ашиг сонирхол үүсгэх, давуу байдал үүсгэх гэж оролдсон тохиолдолд гэрээ хүчингүй болно. Хийсн ажил үйлчилгээний төлбөрийн захиалагч хариуцахгүй гэсэн утгатай 2 заалт орсон байдаг. |
| 3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх. | Олон нийтийн хяналт хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, байгууллагын тоо | - | 3 үйл ажиллагаа, 35 байгууллага | |
| Зорилт 4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах. | | | | |
| 4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/ | Цахимжуулсан үйлжилгээ, зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | - | Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад хөдөөгийн багаас ирж үйлчлүүлж байгаа иргэдэд үйлчилгээг цахимаар олгож байх. Өөрсдөө биеэрээ ирж үйлчилгээ авч байгаа малчдын асуудлыг аль болох хурдан шуурхай зохион байгуулж үйлчилгээний шат дамжлагыг өөрсдөө шийдвэрлэсэн зэрэг тоогоор хагас бүтэн жилээр урамшуулал олгохоор дотоод журрмандаа заасан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | байдаг учраас албан хаагчид хөдөөгийн багуудыг тус бүр хариуцан ирсэн малчдын асуудлыг өөрсдөө дагуулж мэргэжилтнүүдэд асуудлыг танилцуулан түргэн шуурхай шийдвэрлэж хэвшсэн. Хөдөө багийн хурлуудад явахдаа ч явуулын төрийн үйлчилгээг тотмол үзүүлж ирсэн. |
| 4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх. | Хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулсан тоо | - | 2 доошгүй хэлэлцүүлэг зохион байгуулсан байна | Хөдөө багуудын хурал дээр төрийн үйлчилгээ авахад бэрхшээл, хүндрэл байгаа эсэхийг асууж тодруулж ирсэн. Ямар нэг байдлаар гомдол ирээгүй. |
| 4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | ШБҮнэлгээ<br>“АТГ-ын 2022 он үнэлгээ” | Сэтгэл ханамжийн судалгаа авах | |
| Зорилт 5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | | | | |
| 5.1. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах. | Төлөвлөгөө болон тайлан боловсруулж, танилцуулснаар | АТҮХ, Авлигын эсрэг байгууллагын төлөвлөгөө, тайлан | Нийт алба хаагчдад танилцуулсан байна | Сумын ЗДТГ, ЭМТ, СӨББ, ЕБС, Туяа ЕБС, Соёлын төвийн байгууллагууд жил бүр сумын Засаг дарга тай гэрээ батлуулахдаа байгууллагадаа хэрэгжүүлэх Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хамт батлуулдаг. Жилийн эцсээр төлөвлөгөөний биелэлтийг танилцуулж дүгнүүлэхдээ мөн авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг цугт нь дүгнүүлдэг. |
| 5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусган, хэрэгжүүлэх. | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Тухай бүр | |
| Зорилт 6. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах. | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.1. Эрүүгийн хуулийн авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбогдох зүйл заалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан, аймгийн Прокурорын газар, авлигын эсрэг сургагч багш нартай хамтран төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад сургалт, мэдээлэл өгч, зөвлөмж чиглэл хүргүүлэх. | Зохион байгуулсан сургалт, хүргүүлсэн зөвлөмжөөр | 150 | 200 доошгүй удирдах албан тушаалтанд сургалт зохион байгуулсан байна. | - |
| 6.2. Эрсдэл бүхий зарим төрийн байгууллагыг сонгон авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах чиглэлээр тусгайлан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2 доошгүй байгууллага | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа, хөнгөлөлттэй зээл олгож байгаа албан хаагчид хамгийн эрсдэлтэй байдаг учраас ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдүүлгийн хуудсыг тогтмол хөтөлж байх шаардлагыг тавьж ажилладаг. Энэ оны хувьд ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн албан хаагч байхгүй байна. |
| 6.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжид заасан хориглолт хязгаарлалт зөрчсөн томилгоо, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө, орлогын мэдүүлгийн хугацаанд хяналт, шалгалт явуулах, илэрсэн зөрчлийг арилгах. | Хяналт шалгалтын тоогоор | “2022 онд АТГ-аас хяналт шалгалт хийгдсэн” | Хяналт шалгалт зохион байгуулсан байна | Албан тушаалд томилогдохоор нэр дэвшигдсэн улс төрийн 2 албан хаагч, төрийн үйлчилгээний удирдах 3 албан хаагчийн ХАСУМ-ыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн дүгнэлтийн дагуу томилох шийдвэрүүдийг гаргуулсан. Сумын Засаг дарга болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнуудад ХАСУМ авч |
| 6.4.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдэд зориулсан нэвтрүүлэг, контент бэлтгэн түгээх. Орон нутгийн нэр хүндтэй, олны танил хүмүүсээр яриа таниулга хийх. | Нэвтрүүлэг контентийн тоо | - | 2 доошгүй контент, нэвтүүрлэг бэлтгэсэн байна. | Авлигатай тэмцэх газрын фэйж хуудсанд байрлуулсан мэдээллийг тухай бүр шэйрлэн сумын фэйж хуудсуудаар иргэдэд сурталчилан ажиллаж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6.5. Авлигын эсрэг сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан хүүхэд залуучуудад хүргэх үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Монголын Хуульчдын холбооны аймаг дахь салбар зэрэг байгууллагуудтай хамтран шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан иргэн, хүүхэд залуучуудын тоо | 150 | 400 | Авлигын эсрэг төлөвлөгөөг байгууллага бүр тухайн жилдээ гарган албан хаагчдаа авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн ИТХ-аас төрийн байгууллагын албан хаагч нарт авлигын эсрэг хуулийн талаар сургалт зохион байгуулж зөвлөгөө өгч ажилласан. Жил бүрийн 1-р сард хуулийн дагуу ХАСХОМэдүүлэг гаргадаг албан тушаалтнуудаас мэдүүлгийг авч цахим системд бүртгэн ажиллаж байна. Мөн төрийн байгууллагын дарга эрхлэгч нар гэрээт албан газруудтай болон шинээр томилогож буй албан хаагчидтай ашиг сонирхолын зөрчилгүй мэдэгдлийг тухай бүр мэдүүлж хэвшсэн. |